

23. Тэнгэрлэг Эцэг минь, бид Энэтхэгийн хөдөө байгаа эмэгтэйчүүдийг жирэмсэн байх хугацаандаа шаардлагатай эмчилгээ хийлгэж, эх хүүхдийн эрүүл мэнд таны амар тайван дотор сайн байхын төлөө залбирч байна. (Ег. 15:26).

24. Бурхан минь, Индонезид сая сая эмэгтэйчүүд Есүсийг Аврагч, Эзэн гэдэгт итгэдэггүй. Тэднийг өөртөө авчирч зүрх сэтгэлийн өөрчлөөч. (Үйлс 4:12)

25. Эзэн минь ээ, бид Япон дахь TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" ажилчдыг мэргэн ухаан, нигүүлсэл, баяр баясгалангаар үйлчлэх хүчийг өгөгч Ариун Сүнсээр дүүргэн байхын төлөө залбирч байна. (Исаиа 60:1).

26. Аав аа, Өмнөд Солонгост байгаа Хойд Солонгосын 34,000 дүрвэгсэд сайн мэдээг сонсож, Есүс Христийг Аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрөх болтугай. (Еф. 1:13)

27. Бурхан минь ээ, Монголын төрийн түшээдэд эх орныхоо төсвийн мөнгийг ард түмнийхээ сайн сайхны төлөө зөв зарцуулах мэргэн ухааныг хайрлаач. (1 Тим. 6:9-10)

28. Эзэн минь, Себуано, Илокано, Тагалог хэл дээр цацагдаж байгаа "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлэг Филиппиний сонсогчдод хүч чадал, мэргэн ухааныг өгөх болтугай.

29. Балба дахь "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийн олон сонсогч сүмд элсэхийг хүсдэг ч нөхрөөсөө зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Бурхан минь, нөхрүүдийн зүрх сэтгэлийг зөөллөж, эхнэрээ дэмжих болтугай. (Езекиел 11:19).

30. Аав аа, Хятадын сураггүй алга болсон өсвөр насны хүүхдүүдийг хамгаалаач. Алга болсон хүүхдүүдийнхээ төлөө санаа зовсон гэр бүлүүдэд амар тайвныг авчраач. (2 Тес. 3:3)

31. Аав аа, Сингапурт хөдөлмөр эрхэлдэг ээжүүд амьдралынхаа өндөр өртгийг даван туулахын хажуугаар ажил, гэр бүлээ тэнцвэртэй авч явахын төлөө маш их хичээж байна, Тэд Таны доторх жинхэнэ амар амгаланг олж, тайвшрах болтугай. (Матай 11:28-30).



**Найдвартай  
эмэгтэйчүүд**

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다

**2023. 5.**

**Азийн эмэгтэйчүүдэд зориулсан  
залбирал 1**

Бурханы талаарх бидний бодол нь амьдралыг харах дуран болдог. Тиймээс бид Бурханыг зөв мэдэж, зөв харах нь чухал юм. Бурхан бидэнд хамгийн сайныг өгөхийг хүсдэг үнэхээр бидний сайн Эцэг Аав юм. Бид Түүний өмнө итгэлээрээ очиж, Түүний гайхамшигт ажлыг хардаг.

**TWR Korea 북방선교방송**

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층  
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Бурхан минь ээ, Камбож-н "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийн сонсогч нар таны үгийг сонсож, танруу улам ойртохын төлөө орон зай, цаг хугацаагаа зориулах болтугай, Та тэднийг удирдаж, чиглүүлэхдээ зүрх сэтгэлийн сонсоорой. (Дуу. 32:8)

2. Эзэн минь, Хятадад эмэгтэйчүүдийг үнэлж хүндэлдэггүй хүмүүсийн зүрх сэтгэл, оюун бодолд өөрчлөлтийг авчраач. Гэр бүлийн болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоож чадах удирдагчдыг өсгөж хүмүүжүүлж өгөөч. (Ис. 60:18)

3 Эзэн минь, Энэтхэгт COVID-ийн үеэр нөхрөө алдаж, хүүхдүүдээ өсгөж, сургахын тулд ямар ч орлогогүй болсон бэлэвсэн эмэгтэйчүүдийн бүх хэрэгцээг бүрэн дүүрнээр хангаж өгөөч. (Флп. 4:19)

4. Тэнгэрлэг Эцэг минь ээ, Индонези болон Яваны нийт 80 гаруй радио станцууд "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг цацаж байгаад маш их баярлалаа. (Дуу. 71:8)

5. Эзэн минь, бид сайн мэдээг Япон даяар сонсож, хүлээн авахын төлөө залбирч байна. Харанхуйд байгаа хүмүүс Есүс доторх гэрэл гэгээг харж, авралыг хүлээн авах болтугай. (Ис. 9:2)

6. Аав аа, Үе тэнгийн хэт их өрсөлдөөн, сурагчдын хүчирхийллээс болж стресст орсон солонгос өсвөр насны хүүхдүүд танаас амар амгалан, баяр баясгалан, эрх чөлөөг олж авах болтугай. (Иохан 8:32)

7. Монголын агаарын бохирдлоос болж олон хүний эрүүл мэнд тэр дундаа хүүхдийн эрүүл мэнд муудаж байна. Эдгээр хүмүүс Есүсийн нэрээр эдгэрэх болтугай. (Иер. 33:6).

8. Аав аа, амьдралаа залгуулахын тулд биеэ үнэлж байгаа Филиппин эмэгтэйчүүд таны сэтгэлд нийцсэн зөв ажил олж, өөрсдийгөө ямар их үнэ цэнтэй гэдгээ ойлгох болтугай. (Иер. 29:11).

9. Балбын эмэгтэйчүүд "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөрийн оёдол, бичиг үсгийн болон бусад хичээлд хамрагдаж байхдаа мөн сурч мэдсэн мэдлэгээ ашиглан ажил хийж гэр бүлдээ санхүүгийн хувьд туслахдаа Есүсийг улам илүү таньж мэдэх болтугай. (Иохан 17:3)

10. Аав аа, Вьетнамд амьдралын боломж тааруу гэр бүлд өссөн хүүхдүүд эцэг эхийнхээ анхаарал халамж, сурч хүмүүжих орчин нөхцөлийг улам ихээр хүртэх болтугай. (Еф. 6:4)

11. Эзэн минь, Камбожийн TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" багийг олон хүнд бэрхшээлийн ард гаргаж, дэмжиж, бууж өгөхгүй байх хүч чадал өгсөнд бид Таныг магтъя. (Филиппой 4:13).

12. Хятадын Уйгар хэл дээрх "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлэг бэлтгэхийн тулд шинэ продюсер өгсөнд Бурхан Таныг бид магтъя! Түүнд шаардлагатай ур чадварыг хурдан эзэмшихэд нь туслаач. (Сургаалт үгс 4:11).

13. Төгс Хүчит Бурхан минь ээ, бид танаас Энэтхэгийн Махараштра дахь нөхрүүддээ хаягдсан мөн хууль эрх зүйн болон санхүүгийн ямар ч дэмжлэг авч чадахгүй байгаа эхнэрүүдэд туслахыг гуйж байна. (Исаиа 41:10).

14. Эзэн минь, манай Индонезийн багт орон нутгаас санхүүжилтээр дэмжихэд нь туслаач, Шаардлагатай тоног төхөөрөмж авснаар сонсогчтой илүү ойр харилцах боломжтой болох ба тэд улам илүү эрч хүчтэй үйлчлэх юм. (2 Кор. 9:8)

15. Бурхан минь, Япон хүмүүс "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг сонсож, таны хайр, өршөөлийг хүлээн авч, сар бүрийн залбирлын хуанли ашиглан өршөөлийн залбиралд нэгдэх болтугай. (Ис. 52:7)

16. Аав аа, Хойд Солонгосын хилийг өргөн нээж өгөөрэй, ингэснээр радиог дахин түгээж, COVID-19

улмаас үйл ажиллагаа нь түр зогссон "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөрийг дахин үргэлжлүүлэх боломжтой болох юм. (Еф. 2:14)

17. Есүсийн доторх элбэг дэлбэг, амар тайван амьдрал руу эмэгтэйчүүдийг хөтлөхийн тулд "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг удахгүй Монголд нэвтрүүлнэ гэдэгт бид итгэж байна. (Дуу. 16:11)

18. Бурхан минь, радиогүй хүмүүс болон манай нэвтрүүлгийг үзэх боломжгүй газарт байгаа хүмүүс Филиппиний TWR вэбсайтаас "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг олж сонсох болтугай. (Езекиел 3:10).

19. Санхүүгийн хувьд цөхрөнгөө барсан Балбын олон хүмүүс амьдралыг үнэ цэнтэй биш гэж бодож байна. Эзэн минь, санхүүгийн хүнд нөхцөл байдлаас үүссэн амиа хорлох тухай бодлыг тасалж өгөөч. Эдгээр хүмүүс Танаар дамжуулан амьдралын утга учрыг олж авахад нь туслаач. (Иохан 6:35)

20. Бурхан минь, Вьетнамд номлол болон сайн мэдээг түгээх үйл ажиллагааг явуулахыг хориглох хууль батлагдсан. Та хуулийн эрх баригч хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөллөж өгөөрэй. Таны хайр, үг тэдгээр хүмүүст хүрэх болтугай. (2 Тим. 2:9)

21. Аав аа, Камбожид өдөр бүр зам тээврийн ослоор нас барсан хүмүүсийн ар гэрийнхний зүрх сэтгэлийг тайвшруулж, эдгээж өгөөч. Авлига хээл хахуулийг устгаж, эдгээр хохирогчдод шударга ёс тогтоогооч. (Сургаалт үгс 21:15).

22. Эзэн минь, Хятадын удирдагчдад сексийн наймааг таслан зогсоох мэргэн ухааныг өгөөч. Бэлгийн наймааны эсрэг хууль батлагдан мөрдөгдөж, хохирогчид Танаар дамжуулан чөлөөлөгдөж, эдгэрэх болтугай. (Дуу. 72:14)